

**Найм. Бодлогын хэрэгжилтийн гол үр дүн, түүнийг ханган механизм**

**Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат /2007-2015/**

**2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн биелүүлнэ.**

1	Эдийн засгийн эрчимтэй өндөр хурдацтай өсөлтийн үр дүн ажлын байр олноор бий болж хүн амын ядуурал 2 дахин буурна	
2	Хүн амын хөгжлийн индекс 0,83 хувь болох	
3	• 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2000 оныхоос гуравны хоёроор, эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулж, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын халдварын тархалтыг тууштай бууруулах;	
4	бүх салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад мэдэгдэхүйц дэвшил гаргах;	
5	сургуулийн насны хүүхдийг бага боловсролд бүрэн хамруулж, хүйсийн ялгааг арилгах;	
6	жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэх, ажилгүйдэл мэдэгдэхүйц буурах;	
7	хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжрах;	
8	дэд бүтцийн салбарт томоохон зорилтуудыг хэрэгжүүлж, хатуу хучилттай авто замын урт 8000 км-т хүрэх, говийн болон зүүн бүсэд төмөр замын сүлжээ барих ажлын 60 хүртэл хувийг гүйцэтгэх, хоёр дахь төмөр зам барих ажлын 70-аас доошгүй хувийг хийнэ. Гол төмөр замыг цахилгаанжуулах ажлыг шийдвэрлэх;	

9	Монгол Улсын бүх сум байнгын цахилгаантай болж, бүх малчин өрх нар, салхины эрчим хүчээр хангагдах, дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаас гадна цахилгаан эрчим хүч экспортолж эхлэх;	
10	<ul style="list-style-type: none"> <li>гэр бүл бэхжиж, хүн амын тоо өсөх, гэр бүлийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</li> </ul>	
11	хамран сургалтын бохир жин бага боловсролд 99.1, дунд ангид 97.2, суурь боловсролд 98.3 хувьд тус тус хүрэх;	
12	өрхийн эмнэлгийн тогтолцоо бүрэн төлөвших;	
13	сум, аймгийн эмнэлгүүдийн 60 хувь дүүргийн эмнэлгүүд 100 хувь эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр тоноглогдох;	
14	өвчний түүхийг бүрэн цахим картад шилжүүлэх;	
15	эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар 75 хувьд хүрэх;	
16	Улаанбаатар болон томоохон хотуудын агаарын бохирдлыг бүрэн арилгаж, хог хаягдлын цогц менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар орчны бохирдлын эх үүсвэрийг эрс багасгах;	
17	монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, 2015 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 20-иос доошгүй хувь буюу 30 гаруй сая га-д хүрэх;	
18	хот суурин газрын хүн амын 70 хувийн, хөдөөгийн хүн амын 60 хувийн ундны усны хэрэгцээг хангах;	
19	газрын нөөцийн менежментийн боловсронгуй тогтолцоо бүрдэж хэвшсэн байх.	

19	āàçðúí í <sup>º</sup> òèéí íáíæíáíòèéí áíëíâñðííäóé òíäòíèòíí á¿ðäýæ ðýâøñýí áàéð.	
----	--	--





--	--	--